



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

ХУГАЦАА: 2021 -2024 ОН

Орхон аймаг 2021 он

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ, АГУУЛГА

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоёр. Мандатын шинжилгээ

Гурав. Алсын хараа

Дөрөв. Эрхэм зорилго

Тав. Орчны шинжилгээ

Зургаа. Стратегийн зорилго

Долоо. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги

Найм. Стратегийн зорилго ба байгууллагын бүтцийн уялдаа, стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх нэгжийн матриц

Ес. Стратеги төлөвлөгөөний төсөв, эх үүсвэр

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү стратеги төлөвлөгөөний зорилго нь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн хэтийн хандлага, 2021-2024 он хүртэлх хугацаанд баримтлах стратегийн бодлогын зорилт, үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг тогтооход оршино.

Энэхүү зорилгыг шийдвэрлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж, төлөвлөгөөнд тусгалаа. Үүнд:

1. Хүнс, хөдөө аж ахуйн газрын болон нэгжийн ерөнхий, дэд чиг үүрэг, Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчдыг тодорхойлох;
2. Салбар тус бүрийн ойрын дөрвөн жилийн хөгжлийн зорилго, стратегийн зорилт, зорилтот зах зээл, салбар хоорондын хөгжлийн харилцан уялдаа, бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах арга замыг нарийвчлан тодорхойлж, хүрэх үр дүнг тооцох;
3. Салбар тус бүрийн стратегийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах;
4. Салбар тус бүрийн хөгжлийн ойрын 4 жилд хүрэх түвшин, түүнийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлох;
6. Дэвшүүлсэн стратегийн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг тогтоох;
7. Салбарын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх менежментийн арга хэрэгслийг (удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалт, хяналт, үнэлгээ) боловсруулах зэрэг асуудлыг оруулав.
8. Салбарын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх матрицыг боловсруулах.

Төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим:

1. Стратеги төлөвлөгөөнд тусгасан зорилтын хүрээнд хүлээгдэж байгаа өөрчлөлтийг илэрхийлсэн тодорхой зорилт, арга хэмжээг агуулсан байх бөгөөд зорилт, арга хэмжээ нь хоорондоо уялдсан байх;
2. Төлөвлөгөөнд зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр бий болох үр дүн, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байх;
3. Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин нь тухайн жилдээ хэрэгжих боломжтой, тоон ба чанарын утгаар илэрхийлэгдэх, хэмжигдэхүйц, үр дүнг харуулсан байх бөгөөд бодлогын баримт бичиг, статистик тоон мэдээлэл, салбарын мэдээлэлд үндэслэх, арга хэмжээний хүрэх түвшин нь зорилтын үр дүнг илэрхийлсэн байх;
4. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг арга хэмжээ тус бүрээр тусгасан байх;
6. Төлөвлөгөөг тухайн байгууллагын захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж бусад нэгжүүдийн саналыг авч нэгтгэн боловсруулж, байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх.

Төлөвлөгөөний хамрах хүрээ, хугацаа: ХХААХҮЯам, Орхон аймгийн хөдөө аж ахуйн салбарын чиг үүрэгт хамаарах газар тариалангийн салбар, мал аж ахуйн салбар, хүнсний үйлдвэрлэл, хангамж, хөнгөн үйлдвэрийн салбар, жижиг, дунд үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээ, хоршооны салбарын хөгжлийн бодлогыг нэгдмэл байдлаар 2021-2024 он хүртэл хугацаанд хэрэгжүүлэхээр тодорхойлов.

Төлөвлөгөөг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн: Энэхүү төлөвлөгөө нь Хүнс, хөдөө аж ахуйн газрын чиг үүрэгт багтдаг салбаруудын хөгжлийг хооронд нь цогц байдлаар уялдуулан төлөвлөсөн бодлогын баримт бичиг мөн. Уг төлөвлөгөө амжилттай хэрэгжсэнээр хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарууд харилцан бие биенийхээ хөгжлийг тэтгэсэн нэгдмэл эдийн засгийн салбар болон хөгжиж, нэмэгдсэн өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, аймгийн нийгэм, эдийн засагт гүйцэтгэх үүрэг нь дээшлэх боломж бүрдэнэ.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

2.1. Хүнс, хөдөө аж ахуйн газрын чиг үүргийн хуваарилалт:

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		35
үүнээс	Тухайн салбарын хуулийн тоо	28
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	7

Ерөнхий чиг үүрэг-1: Аймгийн хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт		
Үндсэн чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
<p>ҮЧҮ 1: Салбарын хууль тогтоомж, түүний үзэл баримтлал, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бодлогын удирдамжаар хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаад төсөл, хөтөлбөр, олон улсын байгууллагуудын арга хэмжээ хоорондын уялдааг хангаж, салбарын бодлоготой уялдуулах, салбарын чиглэлээр иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулах, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээ, мэдээллээр хангах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн болон жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, шинжлэх ухаан, технологи, инновац, маркетингийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, зөвлөгөө өгөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p>	1.Мал аж ахуйн бодлогын асуудал;	<p>-Хүнс, хөдөө аж ахуйн газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, салбарын төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэд, хэвлэл мэдээллийн байгууллага, нутгийн захиргааны байгууллага болон түүний дэргэдэх байгууллагууд.</p>
	2.Газар тариалангийн бодлогын асуудал;	
	3.Хүнсний үйлдвэрийн бодлогын асуудал;	
	4.Хөнгөн үйлдвэрийн бодлогын асуудал;	
	5.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны бодлогын асуудал;	
	6.Дотоод худалдаа, үйлчилгээний салбарын бодлогын асуудал;	
	7.Шинжлэх ухаан технологи, инновацийн бодлогын асуудал;	
	8.Салбарын эдийн засгийн судалгаа, дүн шинжилгээ;	
<p>ҮЧҮ 2: Салбарын бодлого, зорилттой нийцүүлэн гадаад хамтын ажиллагаа, төрийн болон төрийн бус байгууллага, төсөл, хөтөлбөрийн уялдааг хангах санал боловсруулах, нэгтгэх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p>	9.Олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, хөтөлбөр, төсөл;	
	10.Салбарын нэгдсэн мэдээллийн сангийн асуудал;	
<p>ҮЧҮ 3: Мэдээллийн технологийн хөгжилд нийцүүлэн иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулах замаар үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах, салбарын статистик мэдээ гаргах, мэдээллийн сүлжээ байгуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p>	11.Мэдээллийн технологи, сүлжээ;	
	12.Салбарын статистик, мэдээлэл, судалгаа;	
Ерөнхий чиг үүрэг-1: Захиргаа удирдлагын чиглэлээр		
Үндсэн чиг үүрэг: Захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
<p>ҮЧҮ 1: Төрийн захиргааны удирдлагаар хангах, бүтцийн дотоод зохицуулалт, үйлчилгээг эрхлэх, аймгийн хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хууль, эрх зүйн туслалцаа, зөвлөмжөөр хангах үндсэн үүрэг хүлээж, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг</p>	1.Салбарын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, даргын зөвлөлийн асуудал;	<p>- Хүнс, хөдөө аж ахуйн газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, салбарын төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэд, хэвлэл мэдээллийн байгууллага, аймгийн Төрийн албаны</p>
	2.Хүний нөөц, сургалтын асуудал;	
	3.Тогтоол шийдвэрийн биелэлт, дотоод асуудал;	
	4.Шагнал, төр хувийн хэвшлийн түншлэл;	

<p>хангах, хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийн тайланг гаргах, олон нийттэй харилцах, хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж уламжлах, уялдаа холбоог хангах чиг үүрэг хэрэгжүүлнэ.</p>	<p>5.Өргөдөл, гомдол, орон нутаг, харьяа байгууллага, хөтөлбөр, төслийн биелэлтийн асуудал;</p> <p>6.Байгууллагын архивын асуудал;</p> <p>7.Дотоод хяналтын асуудал;</p> <p>8.Газрын бичиг хэргийн асуудал;</p>	<p>зөвлөлийн салбар зөвлөл, нутгийн захиргааны байгууллага болон түүний дэргэдэх байгууллагууд.</p>
<p>Ерөнхий чиг үүрэг-3: Мал аж ахуйн салбарын чиглэлээр</p>		
<p>Үндсэн чиг үүрэг: Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:</p>	<p>Дэд чиг үүрэг</p>	<p>Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид</p>
<p>ҮЧҮ 1: Мал аж ахуйн үйлдвэрлэл, малын генетик нөөцийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, эрчимжүүлэх, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, усан хангамжийг сайжруулах, малыг байгаль, цаг агаарын эрсдэлээс хамгаалах, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, малчны орлого нэмэгдүүлэх, малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, малын үржил, селекц, генетик нөөцтэй холбоотой бодлого, стратегийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, малын генетик нөөцийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, мэдээллийг тухай бүрд баяжуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p>	<p>1.Уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн асуудал;</p> <p>2.Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн асуудал;</p> <p>3.Малын тэжээл хангамж, үйлдвэрлэл, нөөцийн асуудал;</p> <p>4.Уур амьсгалын өөрчлөлт, гэнэтийн аюул, эрсдэлийн нөлөөллийг бууруулах асуудал;</p> <p>5.Малчдын хөгжлийн асуудал</p> <p>6.Малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохицуулах асуудал;</p> <p>7.Малыг бүртгэх системийн хэрэгжилтийг хангах;</p> <p>8.Малын үржил селекцийн бодлого, технологийн ажил, үйлчилгээний хяналтын асуудал;</p> <p>9.Малын генетик нөөцийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэх асуудал;</p> <p>10.Малын генетик нөөцийг хадгалах, хамгаалах үйл ажиллагааны зохицуулалт, технологийн хяналтын асуудал;</p> <p>11.Малыг ялган тэмдэглэх бүртгэлжүүлэх;</p> <p>12.Малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээ, тайлан, технологийн хяналтын асуудал;</p> <p>13.Бэлчээрийн ургамал хамгаалал, нөхөн сэргээлтийн асуудал;</p> <p>14.Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх;</p>	<ul style="list-style-type: none"> - Хүнс, хөдөө аж ахуйн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар; - Мэргэжлийн хяналтын газар; - Малын удмын сангийн Үндэсний төв; - Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа; - Хөдөө аж ахуйг дэмжих сан; - Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн; - Аймгийн Засаг даргын тамгын газар; - Аймгийн Мал эмнэлгийн газар; - Сумын Засаг даргын тамгын газар; - Сумын Хөдөө аж ахуйн тасаг; - Мэргэжлийн холбоод; - Төрийн бус байгууллагууд; - Олон Улсын байгууллагууд;
<p>Ерөнхий чиг үүрэг-4: Газар тариалангийн салбарын чиглэлээр</p>		

Үндсэн чиг үүрэг: Газар тариалангийн салбарын бодлогыг хэрэгжилтийг хангах үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
<p>ҮЧҮ: Газар тариалангийн үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд тариалангийн үйлдвэрлэлийн байгаль, цаг агаарын эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлж уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, үр, сортын шинэчлэл, хөрсний үржил шимийг сайжруулах, хамгаалах, таримал ургамлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн тогтвортой, хүртээмжтэй хангамжийг бий болгох бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, тариалангийн үйлдвэрлэлд байгаль орчинд ээлтэй техник, технологи нэвтрүүлэн тогтвортой хөгжлийг хангах, эрчимжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p>	1.Үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн таримлын үйлдвэрлэл, хангамж;	<p>-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар; -Аймгийн Засаг даргын тамгын газар; -Сумын Засаг даргын тамгын газар; -Сумын Хөдөө аж ахуйн тасаг; -Аймгийн Мэргэжлийн хяналтын газар; -Хөдөө аж ахуйг дэмжих сан; -Ургамал, газар тариалангийн хүрээлэн; -Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн; -</p>
	2.Газар тариалангийн техникийн хангамж, ашиглалт, засвар үйлчилгээ;	
	3.Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх, усалгааны техник технологийг нэвтрүүлэх;	
	4.Хамгаалагдсан хөрсний тариаланг нэмэгдүүлэх замаар хүнсний нарийн ногооны импортын хэмжээг бууруулах;	
	5.Агуулах зоорь, элеватор, үтрэмийн хангамж, ашиглалт;	

Ерөнхий чиг үүрэг-5: Хүнсний үйлдвэрлэл, хангамжийн чиглэлээр

Үндсэн чиг үүрэг: Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг хангах үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
<p>ҮЧҮ: Хүнсний үйлдвэрлэл, хангамж, худалдааны бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хүнсний болон хоол үйлдвэрлэлд үнэ цэнийн болон кластерийн сүлжээг хөгжүүлэх, хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, импортыг орлох болон экспортлох боломжийг нэмэгдүүлэх, аймгийн хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх, бэхжүүлэх, мэдээллийн цахим санд мэдээлэх чиг үүрэг хэрэгжүүлнэ.</p>	1. Хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдал;	<p>- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар - Аймгийн Засаг даргын тамгын газар; - Аймгийн Мэргэжлийн хяналтын газар; - Аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс; - Аймгийн Эрүүл мэндийн газар; - Аймгийн Мал эмнэлгийн газар; - Сумын Засаг даргын тамгын газар; - Сумын Хөдөө аж ахуйн тасаг; - Мэргэжлийн холбоод; - Төрийн бус байгууллагууд; - Хүнсний үйлдвэрүүд; - Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид; - Худалдаа эрхлэгч, аж ахуй нэгж; - Сүлжээ маркет, хүнсний дэлгүүр; - Бусад үйлчилгээний байгууллагууд;</p>
	2.Баяжуулсан болон органик хүнсний үйлдвэрлэл;	
	3.Исгэлтийн үйлдвэрлэл;	
	4.Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамж;	
	5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамж;	
	6.Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулалт;	
	7.Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамж;	
	8. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал;	

Ерөнхий чиг үүрэг-6: Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын чиглэлээр

Үндсэн чиг үүрэг: Хөнгөн үйлдвэрийн асуудал түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
<p>ҮЧҮ: Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиллах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хөнгөн үйлдвэрийн салбарт экспортын баримжаатай болон импортыг орлох бүтээгдэхүүний нэр, төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, үнэ цэнийн болон кластерын сүлжээг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах, хөнгөн үйлдвэрийн инноваци, технологийн шинэтгэлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p>	<p>1.Хөнгөн үйлдвэрийн салбарын санхүү, хөрөнгө оруулалтын асуудал, хүний нөөцийн судалгаа;</p> <p>2. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын техник, технологийн шинэчлэлт, бүтээлч, эко үйлдвэрлэлийн кластерийн асуудал;</p>	<ul style="list-style-type: none"> - Хүнс, хөдөө аж ахуйн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар; - Аймгийн Засаг даргын тамгын газар; - Аймгийн Мэргэжлийн хяналтын газар; - Сумын Засаг даргын тамгын газар; - Сумын Хөдөө аж ахуйн тасаг; - Мэргэжлийн холбоод; - Хөнгөн үйлдвэрүүд; - Төрийн бус байгууллагууд; - Олон Улсын байгллагууд; - Сүлжээ маркетууд;
Ерөнхий чиг үүрэг-7: Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны салбарын чиглэлээр		
Үндсэн чиг үүрэг: Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны асуудал үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
<p>ҮЧҮ: 1. Ахуйн үйлчилгээний салбарын хөгжлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p>	<p>1.Ахуйн үйлчилгээний салбарын хүний нөөц, мэргэжлийн зэрэг, ур чадвар;</p> <p>2.Ахуйн үйлчилгээний стандартын асуудал;</p> <p>3.Ахуйн үйлчилгээний судалгаа, бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, хөгжүүлэх;</p> <p>4.Иргэдийн тав тухтай амьдрах нөхцөл бололцоог хангах асуудал;</p>	<ul style="list-style-type: none"> - Хүнс, хөдөө аж ахуйн яамны Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар; - Аймгийн Засаг даргын тамгын газар; - Сумын Засаг даргын тамгын газар; - Сумын Хөдөө аж ахуйн тасаг; - Мэргэжлийн холбоод; - Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч; - Үйлчилгээ эрхлэгч иргэн аж ахуй нэгж; - Хоршоо; - Төрийн бус байгууллагууд; - Олон Улсын байгллагууд;
<p>ҮЧҮ: 2. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын хөгжлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p>	<p>5.Жижиг, дунд үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлогын асуудал;</p> <p>6.Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн судалгаа, бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, хөгжлийн бодлого;</p> <p>7.Жижиг, дунд үйлдвэрийн гарааны бизнес, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, борлуулалт, менежментийн асуудал;</p> <p>8.Жижиг, дунд үйлдвэрийн хүнийн нөөцийн хөгжлийн асуудал;</p>	<ul style="list-style-type: none"> - Хүнс, хөдөө аж ахуйн яамны Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар; - Аймгийн Засаг даргын тамгын газар; - Сумын Засаг даргын тамгын газар; - Сумын Хөдөө аж ахуйн тасаг; - Мэргэжлийн холбоод; - Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч; - Үйлчилгээ эрхлэгч иргэн аж ахуй нэгж; - Хоршоо; - Төрийн бус байгууллагууд; - Олон Улсын байгллагууд;
<p>ҮЧҮ: 3. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны салбарын санхүүгийн бус дэмжлэгийн бодлого, хөгжлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p>	<p>9.Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зээлийн батлан даалтын асуудал;</p> <p>10.Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээлийн асуудал;</p>	<ul style="list-style-type: none"> - Хүнс, хөдөө аж ахуйн яамны Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар; - Аймгийн Засаг даргын тамгын газар; - Сумын Засаг даргын тамгын газар; - Сумын Хөдөө аж ахуйн тасаг; - Мэргэжлийн холбоод; - Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч; - Үйлчилгээ эрхлэгч иргэн аж ахуй нэгж; - Хоршоо; - Төрийн бус байгууллагууд; - Олон Улсын байгллагууд;

ҮЧҮ: 4. Хоршооны салбарын хөгжлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.	11.Түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, тээвэр ложистикийн асуудал;	
	12.Хоршооны бизнес хөгжүүлэлт, менежментийн асуудал;	
	13.Хоршооны хүнийн нөөцийн хөгжлийн асуудал;	
	14.Хоршооны судалгаа, бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, хөгжүүлэх асуудал;	

Ерөнхий чиг үүрэг-8: Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр

Үндсэн чиг үүрэг: Санхүү, хөрөнгө оруулалтын асуудал, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ: 3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, төсөв боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, санхүүгийн байдлыг тайлагнах, төрийн сангийн үйл ажиллагааг эрхлэх үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийх, төсвийн шууд захирагчийн төсвийн төсөл, хөрөнгө оруулалт, зардлын жилийн болон дунд хугацааны төсвийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөх, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, батлагдсан төсвийг захиран зарцуулах, тайлагнах, зохицуулалтыг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, төсвийг ил тод мэдээлэх, гадаадын төсөл, хөтөлбөрийн төсвийн нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтыг хангах, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, газрын санхүү, аж ахуйн үйл ажиллагааг тасралтгүй явуулах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд хариуцах чиг үүргийг хэрэгжүүлнэ.	1.Нэгдсэн төлөвлөлтийн асуудал;	<ul style="list-style-type: none"> - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газар; - Аймгийн Засаг даргын тамгын газар; - Аймгийн Мэргэжлийн хяналтын газар; - Аймгийн Мал эмнэлгийн газар - Сумын Засаг даргын тамгын газар; - Сумын Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд; - Сумын Хөдөө аж ахуйн тасаг; - Мэргэжлийн холбоод; - Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч; - Үйлчилгээ эрхлэгч иргэн аж ахуй нэгж; - Хоршоо; - Төрийн бус байгууллагууд; - Олон Улсын байгллагууд;
	2.Салбарын авлага, өр төлбөрийн асуудал;	
	3.Хөрөнгө оруулалтын асуудал;	
	4.Төсвийн гүйцэтгэл, тайлан, хөтөлбөрийн асуудал;	
	5.Төсвийн урамшуулал асуудал;	
	6. Хөтөлбөр, төслийн бүртгэл, санхүүжилтийн асуудал;	
	7. Төрийн сангийн асуудал;	

Ерөнхий чиг үүрэг-9: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр

Үндсэн чиг үүрэг: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ: 1. Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд	1.Хөнгөн үйлдвэр, жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ;	<ul style="list-style-type: none"> - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар; - Аймгийн Засаг даргын тамгын газар;
	2.Хүнсний үйлдвэрийн салбарын хяналт- шинжилгээ, үнэлгээ;	

салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, биелэлтийн хэрэгжилтийг хангуулах, хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх; салбарын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.	3.Газар тариалангийн салбарын хяналт- шинжилгээ, үнэлгээ;	<ul style="list-style-type: none"> - Аймгийн Мэргэжлийн хяналтын газар; - Сумын Засаг даргын тамгын газар; - Сумын Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд; - Сумын Хөдөө аж ахуйн тасаг; - Мэргэжлийн холбоод; - Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч; - Үйлчилгээ эрхлэгч иргэн аж ахуй нэгж; - Хоршоо; - Төрийн бус байгууллагууд; - Олон Улсын байгллагууд;
	4.Мал аж ахуйн салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ;	
6. Дотоод аудитын асуудал;		
ҮЧҮ: 2. Төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, төслийн арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн, гүйцэтгэлийн болон нийцлийн дотоод аудит хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гарган үр ашгийг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.	7.Санхүүгийн дотоод аудитын асуудал;	
	8.Гүйцэтгэлийн дотоод аудитын асуудал;	

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

3.1. Аймгийн хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд, хөнгөн үйлдвэр, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын хөгжлийг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

3.2. Стратегийн тэргүүлэх чиглэл:

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь дор дурдсан үйл ажиллагааны стратегийн тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

3.2.1. Мал аж ахуй, газар тариалан, хүнсний болон хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо, худалдаа үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх;

3.2.2. Малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, нөөцийг тогтоох, төлөв байдлыг үнэлэх, бүртгэх, тэдгээрийг тогтвортой ашиглах, хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарц, чанарыг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлэх;

3.2.3. Хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, усан хангамжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах;

3.2.4. Тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, эрчимжүүлэх, таримал ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх, тариалангийн эдэлбэр газрыг эргэлтэд оруулах, хөрсний үржил шимийг сайжруулах, хамгаалах, ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.2.5. Байгалийн гэнэтийн аюул, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах;

3.2.6. Салбарын үйлдвэрлэлд шинэ, дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, нутагшуулах, техникийн шинэчлэлийг хийх;

3.2.7. Хөнгөн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, импортыг орлох, экспортын баримжаатай сүлжмэл, нэхмэл, оёмол хувцас, арьс, ширэн бүтээгдэхүүн, хэрэгслийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;

3.2.8. Хүн амын эрүүл, баталгаат хоол, хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний хангамж, шим тэжээлийн зохистой хэрэглээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах;

3.2.9. Мэдээллийн технологийн хөгжилд нийцүүлэн иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулан, шуурхай, ил тод байдлыг хангах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх;

3.2.10. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эдийн засаг, төсвийн тооцоо, хөрөнгө оруулалт, урсгал зардлын төсвийн төлөвлөлт, санхүү, төсвийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, төсвийн ил тод байдлыг хангаж ажиллах.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

4.1. Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь салбарын бодлогыг оновчтой хэрэгжүүлэх замаар эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг дэмжих, түүхий эдийн нөөцийг зохистой

ашиглах, үйлдвэрлэлийн орлого, бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнсээр хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

5.1. Салбарын хүний нөөц

Аймгийн хүнс, хөдөө аж ахуйн салбарт ажиллах боловсон хүчинг Улаанбаатар хотын ХААИС, Дархан-Уул аймаг дахь ХААИС-ын салбар, аймгийн Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд бэлтгэгдэж байна. Одоогийн байдлаар салбарт давхардсан тоогоор 11893 боловсон хүчин ажиллаж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын ажиллах хүч:

Салбарууд	2016	2017	2018	2019
Аймгийн нийт ажиллах хүчний тоо	33133	32215	34935	31583
ХХААХҮ-ийн салбарын ажиллах хүч:	11369	11968	11263	11893
- Хөдөө аж ахуй	914	2503	1090	1648
- Боловсруулах үйлдвэрлэл	4185	2961	2903	3937
-Худалдаа, үйлчилгээ	5081	5788	6692	5396
-Нийтийн хоолны үйлчилгээ	1189	716	578	912
Нийт ажиллах хүчинд ХХААХҮ-ийн салбарын эзлэх хувь	34.3	37.1	32.2	37.6

5.2. Санхүүгийн нөөц

БАТЛАГДСАН ТӨСӨВ /сая төгрөг/

№	Хөтөлбөр	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
1	Байгууллагын батлагдсан төсөв	217704,1	279622,5	297763,2	297239,1	350478,4
2	Мал аж ахуйн салбар	17632.00	54098.00	61395.00	61370.70	10260.00
3	Хүнс, газар тариалангийн салбар	3900.00	3191.00	1497.90	6513.3	4820.00
4	“Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр					6,644.00
5	“Өрхийн тариалан дэмжих” дэд хөтөлбөр		126375.00	62232.9	80070.0	134351.9
6	ХШҮнэлгээний зардал		1497.00		1376.70	
	Дүн	239236.1	464783.5	422889.0	446569.8	506553.4

5.3. Мэдээллийн болон технологийн нөөц

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2018 оны 05 дугаар сараас И-Оффис системийг ашиглан аймгийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлагууд, сумдын Засаг даргын Тамгын газар, багууд, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудтай харилцаж байна. Орхон.Хүнс, хөдөө аж ахуйн газар байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл, сурталчилгаа хүргэн ажиллаж байна.

5.4. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт

5.4.1. Салбарын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт	Зорилтот түвшин				
			2020	2021	2022	2023	2024	
1	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь	хувь	0	5.4	8.4	8.4	8.4	

2	Малын тоо	мянган толгой	136.9	138.3	137.0	136.2	137.9
3	Хөдөө аж ахуйгаас бэлтгэсэн малын мах	тонн	1586.1	1500.0	1500.0	1500.0	1550.0
4	Хөдөө аж ахуйгаас бэлтгэсэн сүү	мянган литр	2091.3	2000.0	2000.0	2000.0	2100.0
5	Хураан авсан үр тариа	мянган тонн	10.2	9.3	9.3	9.4	9.5
6	Хураан авсан малын тэжээл бусад	мянган тонн	1.4	0.5	0.5	0.5	0.5
7	Хураан авсан төмс, хүнсний ногоо	мянган тонн	10.3	8.7	8.8	8.9	9.2

5.5. Оролцогчдын шинжилгээ

5.5.1. Нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажилласан байдал:

№	Байгууллагын нэр	Хамтын ажиллагааны гэрээ, төслийн нэр	Эхэлсэн он	Дууссан он
1	Аймгийн Засаг даргын тамгын газар	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын урт болон дунд хугацааны бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт	Жил бүр	Одоог хүртэл
2	Баян-Өндөр, Жаргалант сумын Засаг даргын тамгын газар	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын урт болон дунд хугацааны бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт	Жил бүр	Одоог хүртэл

5.5.2. Төрийн өмчит хуулийн этгээдүүдтэй хамтран ажилласан байдал:

№	Байгууллагын нэр	Хамтын ажиллагааны гэрээ, төслийн нэр	Эхэлсэн он	Дууссан он
1	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	Орхон аймаг, Эрдэнэт хотын Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай хамтран ажиллах гэрээ “Орон нутгийн Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээг давуу эрхтэйгээр худалдан авах”	2020	2024
2	"Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк" ОНӨААТҮГ	Сургалт, судалгаа	2019	2024

5.5.3. Олон улсын байгууллагуудтай хамтран ажилласан байдал:

№	Байгууллагын нэр	Хамтын ажиллагааны чиглэл, гэрээ, төслийн нэр	Эхэлсэн он	Дууссан он
1	Швейцарын хөгжлийн агентлаг	“Монгол ногоо” хөтөлбөр;	2016	Одоог хүртэл
2	ХБНГУ-ын Засгийн газар	“Монгол Улс дахь Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил II” төсөл;	2016	Одоог хүртэл
3	Азийн хөгжлийн банк	“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт” төсөл	2018	Одоог хүртэл

4	Азийн хөгжлийн банк	“Эх үүсвэртэй батлан даалтын төсөл”	2017	Одоог хүртэл
---	---------------------	-------------------------------------	------	--------------

5.5.4. Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай хамтран ажилласан байдал:

№	Байгууллагын нэр	Хамтын ажиллагааны гэрээ, төслийн нэр	Эхэлсэн он	Дууссан он
1	ХААИС, Дархан-Уул аймгийн Ургамал, газар тариалангийн хүрээлэн	Сургалт, судалгаа	Жил бүр	Одоог хүртэл

5.5.5. Иргэний нийгмийн болон олон нийтийн байгууллагуудтай хамтран ажилласан байдал:

№	Байгууллагын нэр	Хамтын ажиллагааны гэрээ, төслийн нэр	Эхэлсэн он	Дууссан он
1	Байгууллага № 1. Төрийн бус байгууллагууд “Хөгжлийн шийдэл” ТББ-ын “BEST” хөтөлбөр; Орхон аймгийн “Хоршоологчдын холбоо”, “Нэмүү өртөгт бүтээгдэхүүн хөгжүүлэх төв” НҮТББ,	Зөвлөх үйлчилгээ, сургалт, судалгааны чиглэлээр	Жил бүр	Одоог хүртэл
2	Байгууллага № 2. Орхон аймгийн “Хүнсчдийн холбоо”, “Оёдолчдын холбоо”, “Фермерүүдийн холбоо”, “Үсчин гоо сайханчдын холбоо”	Үзэсгэлэн яармаг, туршлага судалгааны чиглэлээр	Жил бүр	Одоог хүртэл
3	Байгууллага № 3. Баян-Өндөр, Жаргалант сумын мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжүүд	Малд үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийх, сургалт зохион байгуулах чиглэлээр	Жил бүр	Одоог хүртэл

5.6. Гадаад зах зээлийн шинжилгээ

5.6.1. Хөрш орнуудын зах зээлд хийсэн шинжилгээ /ОХУ, Хятад/

5.6.1.1. Экспортлогч орны тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд баримталж байгаа бодлого (БНХАУ)

Хүнсний ногоо: 2020 оны эхний хагас жилийн байдлаар, БНХАУ-ын хүнсний ногооны экспортын хэмжээ 5.5 сая тонн буюу 7.0 тэрбум ам.доллараас давсан үзүүлэлттэй байгаа бөгөөд оны эцсийн судалгаагаар 10.0 сая тонн хүрэх төлөвтэй байна. 1.0 тонн хүнсний ногоо дунджаар 1270 ам.доллараар худалдаалагдаж байна. Тус улсын Шань дунг муж нь хүнсний ногооны тариалалт, үйлдвэрлэлээр 1-рт орж 81.0 сая тонн хэмжээний хүнсний ногоо үйлдвэрлэж байна. БНХАУ нь дэлхийн хүнсний ногооны томоохон экспортлогч улсуудын нэг бөгөөд дэлхий нийтийн хүнсний ногооны хэрэгцээ нэг жилд дунджаар 10.4 хувиар өсч байна. Энэ хэмжээгээр Хятадын үйлдвэрлэл нэмэгдэж байна. БНХАУ-ын Төрийн зөвлөлөөс корона вирусын цар тахалтай холбоотой хүнсний ногоо болон жимс, жимсгэнийн экспортод ямар нэгэн хязгаарлалтын арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

5.6.1.2. Экспортлогч орны тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд баримталж байгаа бодлого (ОХУ)

Элсэн чихэр: ОХУ нь 2020 онд 5.6 – 6.2 сая тонн элсэн чихэр үйлдвэрлэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд 2019 оны 10-р сараас 2020 оны 9-р сарыг дуустал 1.8 сая тонн элсэн чихэр гадаадын улс орнуудад нийлүүлж дэлхийн зах зээлд элсэн чихрийн экспортоор 7-р байранд орж байна. ОХУ-аас экспортлох элсэн чихэрт ямар нэгэн хориг одоогийн байдлаар байхгүй байна.

Ургамлын тос: ОХУ нь 2019 оны 09 дүгээр сараас 2020 оны 06 дугаар сар хүртэл 5.57 сая тонн наран цэцгийн тос үйлдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 20.7% нэмэгдсэн бөгөөд 2020 оны 08-р сарын 01-ний байдлаар наран цэцгийн тосны нөөц 555.0 мянга гаруй тонн болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 54.2% -иар өссөн байна. БНХАУ, Турк, Энэтхэг, Египет, Узбекистан зэрэг бусад улс орнууд ОХУ-аас ургамлын тос импортолж байна. ОХУ-аас экспортлох ургамлын тосонд одоогийн байдлаар ямар нэгэн хориг байхгүй байна.

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

6.1. Хүнс, хөдөө аж ахуйн газрын тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ:

6.1.1. Захиргааны удирдлагаар хангах, бүтцийн дотоод зохицуулалт, үйлчилгээг эрхлэх, байгууллагын хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах;

6.1.2. Мал аж ахуй, газар тариалан, хүнсний болон хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо, худалдааны салбарын хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, хэрэглэгчдийг мэдээ, мэдээллээр хангах;

6.1.3. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бодлого болон малын генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг тодорхойлох, хадгалах, хамгаалах, тогтвортой ашиглах, судлан хөгжүүлэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;

6.1.4. Газар тариалангийн үйлдвэрлэлийн бодлого болон хөрс, ургамал хамгаалал, үр сортын шинэчлэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;

6.1.5. Үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;

6.1.6. Хүнс, хоол үйлдвэрлэл, худалдааны бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;

6.1.7. Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах;

6.1.8. Төсвийн шууд захирагчийн эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагааг зохион байгуулах.

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт	Үр дүнгийн үзүүлэлт хүрэх түвшин			
		2019/2020 он		2021 он	2022 он	2023 он	2024 он
Ерөнхий чиг үүргийн нэр: Салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт							
1	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хэрэгжилтийн дундаж хувь 85%	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувиар тооцно.	Хэрэгжилтийн хувь 90%	Хэрэгжилтийн хувь 95%	Хэрэгжилтийн хувь 100%	Хэрэгжилтийн хувь 100%
Ерөнхий чиг үүргийн нэр: Мал аж ахуйн салбарын чиглэлээр							
2	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг чадавхжуулах сургалтад хамруулах, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах	-	Чадавхижуулах сургалтад хамрагдсан эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн тоо	-	2-оос доошгүй сургалтад хамруулсан байна.	2-оос доошгүй сургалтад хамруулсан байна.	2-оос доошгүй сургалтад хамруулсан байна.
3	Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх	өвс 190 тн, тэжээл 70 тн	Өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэлтийн хувь	Аюулгүйн нөөцийг 100% бэлтгэнэ.	Аюулгүйн нөөцийг 100% бэлтгэнэ.	Аюулгүйн нөөцийг 100% бэлтгэнэ.	Аюулгүйн нөөцийг 100% бэлтгэнэ.
4	Эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх ажлыг өргөжүүлэн, фермерүүдийг дэмжих	Үхрийн фермер 15, гахай фермер 1, тахианы аж ахуй 5, зөгийн 14 аж ахуйн нэгж	Дэмжлэгийн тоо /мөнгөн дүн/	-	Төсөл хөтөлбөрт хамруулан дэмжсэн байна.	Төсөл хөтөлбөрт хамруулан дэмжсэн байна.	Төсөл хөтөлбөрт хамруулан дэмжсэн байна.
5	Худаг уст цэгийг шинээр гаргах болон сэргээн засварлаж малчдад эзэмшүүлэх	Бэлчээрт 71 худаг ашиглагдаж, малчин өрхийн 80% усаар хангагдсан.	Шинээр гаргасан, сэргээн засварласан худгийн тоо	-	2 худаг шинээр, 2 худаг сэргээн засварлана	2 худаг шинээр, 2 худаг сэргээн засварлана	2 худаг шинээр, 2 худаг сэргээн засварлана
6	Бэлчээрт үлийн цагаан оготны тандалт судалгаа хийх	Бэлчээрийн тандалт, судалгааг бэлчээрийн 30%-д хийсэн байна.	Тандалт судалгаа хийгдсэн байна.	-	Бэлчээрийн тандалт, судалгааг бэлчээрийн 10%-д хийсэн байна.	Бэлчээрийн тандалт, судалгааг бэлчээрийн 10%-д хийсэн байна.	Бэлчээрийн тандалт, судалгааг бэлчээрийн 10%-д хийсэн байна.
7	Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх	496 толгой хуц, ухна тоологдсоноос 81% буюу 402 толгой хуц, ухныг 3 суурьт ялган төвлөрүүлсэн.	Ялган төвлөрүүлсэн бог малын хээлтүүлэгчийн эзлэх хувь	-	Бог малын хээлтүүлэгчийн 80-аас дээш хувийг ялган төвлөрүүлнэ.	Бог малын хээлтүүлэгчийн 80-аас дээш хувийг ялган төвлөрүүлнэ.	Бог малын хээлтүүлэгчийн 80-аас дээш хувийг ялган төвлөрүүлнэ.
8	Мал сүрэгт үзлэг ангилалт, ялган тэмдэглэгээ хийх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах	35.8 мянган толгой малд үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийсэн.	Үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийсэн малын тоо	Нийт богийн хээлтүүлэгчийг 100, богийн хээлтэгчийн 60 хүртлэх хувийг хамруулна	Нийт богийн хээлтүүлэгчийг 100, богийн хээлтэгчийн 60 хүртлэх хувийг хамруулна	Нийт богийн хээлтүүлэгчийг 100, богийн хээлтэгчийн 60 хүртлэх хувийг хамруулна	Нийт богийн хээлтүүлэгчийг 100, богийн хээлтэгчийн 60 хүртлэх хувийг хамруулна
Ерөнхий чиг үүргийн нэр: Газар тариалангийн салбарын чиглэлээр							

10	Төмс, хүнсний ногооны техник шинэчлэлийг үргэлжлүүлэн, ашиглалтыг сайжруулан, агропарк байгуулах	Агро үйлчилгээний төвд 41.8 сая төгрөгийг шийдвэрлэн LOVOL-824 трактор худалдан авсан.	Агропарк байгуулагдсан байна.	Шаардагдах техник, тоног төхөөрөмж худалдан авсан байна.	Үйл ажиллагаа жигдэрсэн байна.	Үйл ажиллагаа жигдэрсэн байна.	Үйл ажиллагаа жигдэрсэн байна.
11	Төмс, хүнсний ногооны талбайг хашаажуулах ажлыг зохион байгуулах	Жаргалант суманд төмс, хүнсний ногооны 250 га талбайг хашаажуулсан.	Хашаажуулалт хийгдсэн талбайн хэмжээ	-	Төмс, хүнсний ногооны 20 га талбайг хашаажуулна.	Төмс, хүнсний ногооны 20 га талбайг хашаажуулна.	Төмс, хүнсний ногооны 20 га талбайг хашаажуулна.
12	Усалгааны тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй зээлээр худалдан авахад иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин ажиллах	1 аж ахуйн нэгж 50 га талбайн инженерийн хийцтэй услалтын системийн дэмжлэгт хамрагдсан.	Дэмжлэгт хамрагдсан аж ахуй нэгжийн тоо	Аж ахуйн нэгжийг услалтын системийн дэмжлэгт хамруулна.	-	Аж ахуйн нэгжийг услалтын системийн дэмжлэгт хамруулна.	-
13	Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Жил бүр 1000 өрхийг хөтөлбөрт хамруулсан.	Хөтөлбөрт хамрагдсан өрхийн тоо	Хөтөлбөрийн хэрэгжилт 30%	Хөтөлбөрийн хэрэгжилт 60%	Хөтөлбөрийн хэрэгжилт 80%	Хөтөлбөрийн хэрэгжилт 100%
Ерөнхий чиг үүргийн нэр: Хүнсний салбарын чиглэлээр							
14	“Эрүүл Хүнс-Эрүүл Монгол Хүн” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж хүн амын хүнсний хэрэгцээт мах, төмс, гурилыг бүрэн, хүнсний ногооны 50-аас доошгүй хувийг орон нутгийн үйлдвэрлэлээс хангах	Хангамж /хувь/: Малын мах- 90.7, сүү-45.3, гурил- 0.7, Төмс-100, хүнсний ногоо-72.6, жимс, жимсгэнэ-0.1	Хангамжийн хувиар тооцно.	Хангамж: Малын мах- 92.0, сүү- 50.0, гурил- 10.0, Төмс-100, хүнсний ногоо-60.0, жимс, жимсгэнэ-0.2	Хангамж: Малын мах- 94.0, сүү-50.0, гурил- 15.0, Төмс-100, хүнсний ногоо-65.0, жимс, жимсгэнэ-0.3	Хангамж: Малын мах- 94.0, сүү- 55.0, гурил- 20.0, Төмс-100, хүнсний ногоо-70.0, жимс, жимсгэнэ-0.3	Хангамж: Малын мах- 95.0, сүү-55.0, гурил- 40.0, Төмс-100, хүнсний ногоо-75.0, жимс, жимсгэнэ-0.3
15	Хаврын хүнсний улирлын нөөц бүрдүүлэх зорилгоор махны нөөц бүрдүүлэх	Хаврын хэрэгцээт махны 25%- буюу 301.1 тн мах бэлтгэсэн.	Хаврын махны хангалтын хувь	30-аас доошгүй хувийг хангана.	30-аас доошгүй хувийг хангана.	30-аас доошгүй хувийг хангана.	30-аас доошгүй хувийг хангана.
